



## Баянзүрх дүүргийн тэргүүний 82-р цэцэрлэгээс эрхлэн “Тоглоом, тоглоомын аргачлал-3” үзүүлэх ажлыг зохион байгууллаа.

Байгууллагын төлөвлөгөөнд тусгасны дагуу цэцэрлэгийн хүүхэд бүрийг хөгжүүлэх үзэл баримтлал, сургалтын хөтөлбөрийг хэргэжүүлэх ажлын хүрээнд “Тоглоом, тоглоомын аргачлал-3” үзүүлэх ажлыг 3 дахь жилдээ зохион явууллаа. Уг арга хэмжээнд Баянзүрх дүүргийн БХ-ийн дарга М.Цогзолмаа, мэргэжилтэн Ц.Энхтуяа, НБГ-ын СӨБ, цэцэрлэгийн менежмент хариуцсан ахлах мэргэжилтэн З.Болормаа, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш нарын төлөөлөл оролцлоо.

Энэ удаагийн арга хэмжээ нь 2-3 настай хүүхдэд зориулсан барьж байгуулах модон тоглоомыг 92-оос 276 ширхэгтэйгээр бүтээн сургалтад ашиглаж үр дүнгээ тооцсон туршлагаа түгээж байгаагаараа онцлог юм.





**“Тоглоом, тоглоомын аргачлал- 1” төсөлт ажил 22 төрлийн 1500 тоглоом**



**“Тоглоом-тоглоомын аргачлал- 2” төсөлт ажил 7200 ширхэг тоглоом**



### Олон хувилбарт шоо



Багш нарт зориулсан “Тоглоом-тоглоомын аргачлал-1,2,3” үзүүлэх ажил, сургалтыг багш нарт зохион байгуулах саналыг оролцогчид олонтаа санал болгосноос энэхүү арга хэмжээний үр дүнг тооцон харж болно.